



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

᠑᠙᠑᠑ оны ᠐᠑ сарын ᠐᠖ өдөр

Дугаар ᠕/᠔54

Мандалговь

“Дундговь түншлэл-2022” үзэсгэлэн,  
худалдаа зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Дундговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3 дугаар зүйлийн 3.3.10, Дундговь аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 4 дүгээр зүйлийн 4.1.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүн амын хүнсний болон өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний хангамжийг дотоодын үйлдвэрлэлээр хангах өргөн боломжийг бүрдүүлэх, дэвшилтэт технологийг нэвтрүүлж стандартын шаардлага хангасан үйлдвэрлэлийн боловсруулах түвшинг ахиулах, харилцан туршлага солилцох түншлэл тогтоох, үйлдвэрлэл үйлчилгээг сурталчлах зорилгоор “Дундговь түншлэл-2022” үзэсгэлэн худалдааг 2022 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр “Чагдаржав”-ын талбайд зохион байгуулсугай.

2. “Дундговь түншлэл-2022” үзэсгэлэн худалдаа зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, шаардагдах зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. “Дундговь түншлэл-2022” үзэсгэлэн худалдаанд оролцсон байгууллага, аж ахуйн нэгж, үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг шалгаруулах номинаци, шалгуур үзүүлэлтийг гаргаж, нийт сумд, байгууллага, аж ахуйн нэгж, үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийг өргөнөөр оролцуулж, үр дүнтэй зохион байгуулахыг ажлын хэсэг (Н.Түвшинжаргал)-т үүрэг болгосугай.

4. Үзэсгэлэн худалдаанд шаардлагатай 7,530,000 (Долоон сая таван зуун гучин мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (Н.Энхмарт)-д тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц. МӨНХБАТ 4822111192